

## АГУУЛГА

Нэг. Ерөнхий тойм

Байгууллагын үндсэн үйл ажиллагаа

- 1.1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд
- 1.2 Улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай, боловсронгуй болгох ажлын хүрээнд
- 1.3 Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд
- 1.4 Хүний нөөцийн ажлын хүрээнд
- 1.5 Сургалтын ажлын хүрээнд
- 1.6 Санхүү төлөвлөлт, аж ахуйн ажлын хүрээнд
- 1.7 Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд
- 1.8 Мэдээллийн технологийн чиглэлээр
- 1.9 Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд

Хоёр. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа

- 2.1 Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд
- 2.2 Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд
- 2.3 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд
- 2.4 Улсын бүртгэлийн хяналт шалгалтын ажлын хүрээнд хийсэн ажил
- 2.5 Улсын бүртгэлийн архивын ажлын хүрээнд
- 2.6 Бичиг баримтжуулах ажлын хүрээнд

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд

Дөрөв. Ковид-19 цар тахлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Тав. Зохион байгуулсан бусад ажил

Зургаа . Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Долоо . Санал /Тулгамдаж буй асуудал/

# НИЙСЛЭЛ ДЭХ УЛСЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## НЭГ. ЕРӨНХИЙ ТОЙМ

Нийслэл дэх улсын бүртгэлийн газар нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрөөс явуулж буй бүртгэлийн талаарх бодлого чиглэл, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон тус газраас 2021 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хуульд заасан улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг үзүүлэх гэсэн 2 үндсэн чиг үүргийн хүрээнд Газрын дарга, Захиргаа удирдлагын хэлтэс /11/, Харилцагчийн үйлчилгээний хэлтэс /4/, Архивын хэлтэс /9/, Дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтэс /385/ гэсэн нэгжүүдтэйгээр нийт 410 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын 1.466.000 /нэг сая дөрвөн зуун жаран зургаан мянга / гаруй иргэнд төрөөс явуулж буй улсын бүртгэлийн талаарх бодлого шийдвэрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, өөрийн харьяа 187 нэгжээс Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.

## **1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:**

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын 3 тогтоолын 11 заалт, нийт 3 шийдвэрийн 11 заалтыг хяналтанд авч хэрэгжүүлэн ажиллалаа. Эдгээрээс тайлант хугацааны зорилтод бүрэн хэрэгжсэн 11 байгаа бөгөөд хэрэгжилт хувьтай байна.

УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар төрийн захиргааны байгууллага, агентлагын дарга нарт үүрэг болгосон заалт бүрийг хяналтад авч, хяналтын хуудас хөтлөн ажиллаж байна. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд улирал тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, газар хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлт болгон ашиглаж байна.

Тайлангийн хугацаанд Засгийн газрын тогтоол 1, Улсын бүртгэлийн ерөнхий газраас үйл ажиллагаатай холбоотой 4 тушаал, хүний нөөцтэй холбоотой 73 тушаал, 11 үүрэг, чиглэл, 3 зөвлөмж, Нийслэлийн Засаг даргаас 3 захирамж, 1 тогтоол, 7 чиглэл, Нийслэлийн онцгой комиссоос 1 тогтоол, 1 хурлын тэмдэглэл, 1 тушаал, НЗД-ын 1 захирамж, 5 үүрэг чиглэл, 1 заавар зөвлөмж тус тус ирснийг хяналтанд авч, хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.

### ***Хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төсөлд санал өгөх талаар***

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн бусад байгууллагаас санал авахаар ирүүлсэн дараах хууль, дүрэм, журмын төсөлд санал өгч ажиллав. Үүнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найрууллагын төсөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалд, Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспортын бэлдцэд бичилт хийх үйлдвэрийн үйл ажиллагааг зохицуулах журмын төсөл, УБЕГ-аас ирүүлсэн “Улсын бүртгэлийн байгууллагын 2019-2021 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, “Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”, Улсын бүртгэлийн байгууллагын “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”, Улсын бүртгэлийн ерөнхий газрын “НЭГ ИРГЭН-НЭГ БҮРТГЭЛ” хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, Итгэмжлэгдсэн ажилтантай байгуулах ажил гүйцэтгэх гэрээний төсөл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт явагдах УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын төсөл, Улсын бүртгэлийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал, Нийслэлийг хөгжүүлэх 2022 оны жилийн төлөвлөгөөний санал, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх зураг төсвийн төслийг тус тус албан хаагчдад танилцуулж, саналыг холбогдох газруудад хүргүүлсэн.

## **1.2 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХЯЛБАРШУУЛЖ, ТҮРГЭН ШУУРХАЙ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах, иргэдийн төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чанар хүртээмжтэй авах нөхцлийг бүрдүүлэх дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. “Хотын засаглалыг сайжруулах төслийн хүрээнд азийн хөгжлийн сангийн санхүүжилтээр иргэдийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийг чирэгдэлгүй төлөх боломжоор хангаж алслагдсан хороодод цахим төлбөрийн хэрэгсэл болох пос машиныг байрлуулан ажилласан. 2021 оны эхний хагас жилийн байдлаар гэрэгэ насыг ХУД-ийн 1,3,9,12-р хороо, Баянгол дүүргийн 4,8,12,17-р хороо, Баянзүрх дүүргийн 2,24,28-р хороо-р хороо, Сүхбаатар дүүргийн 1,5,10,12-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 1,7,20,42-р хороо, Чингэлтэй дүүргийн 12-р хороо нийт 24 хороонд шинээр байрлуулан ажилласан. 2021 оны 5 сарын байдлаар Гэрэгэ киоск- 48049 иргэн, төрийн төлбөр тооцооны И-баримт аппликейшнээр 40, нийт 48089 иргэн үйлчилгээ авсан.
2. Шинээр байгуулагдсан Сонгинохайрхан дүүргийн 11 /32-43/ хороо, Налайх дүүргийн 8-р хороо, хотоос алслагдсан хороо болох Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, Баянзүрх, Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст 4G төхөөрөмжийг суурилуулж лацдан улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгсөн. Уг төхөөрөмжийг суурьлуулснаар шилэн кабель холбогдох боломжгүй, улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээ орох боломжгүй байсан хороодыг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээтэй болгож иргэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцлөөр хангагдсан.

## **1.3 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

***Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллав.***

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвлөл, шуурхай хуралдаан, холбогдох ажлын хэсгүүд, мөн Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаан, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тухай бүр оролцож өгөгдсөн үүрэг даалгаварын хүрээнд Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын удирдах албан хаагчдын шуурхай хуралдааныг 24 удаа цахимаар зохион байгуулж, хурлаас нийт 102 үүрэг даалгавар өгч, биелэлтийг гарган ажилласан.

***УБЕГ болон НЗДТГ бусад дээд газарт дараах тайлан, мэдээ, судалгааг хүргүүлж ажиллав.***

Тус газар нь 2021 онд нийт 43 төрлийн тайлан, мэдээг давхардсан тоогоор 280 удаа холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт -1 удаа
2. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт-1 удаа

3. Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт-1 удаа
4. НИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилтийн тайлан-1 удаа
5. Байгууллагын хагас жилийн үйл ажиллагааны тайланг УБЕГ болон НЗД-т-1 удаа
6. Газрын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт-1 удаа
7. НУБГ-ын 2020 оны санхүүгийн тайлан-1 удаа
8. НУБГ-ын Нийгмийн даатгалын тайлан-5 удаа
9. НУБГ-ын Хүн амын орлогын албан татварын тайлан -1 удаа
10. НУБГ-ын орлогын тайлан-5 удаа
11. Үнэт цаасны бар кодын тайлан-5 удаа
12. Төсвийн гүйцэтгэл-5 удаа
13. Иргэний улсын бүртгэлийн сарын тоон мэдээ-5 удаа
14. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас өгсөн үүрэг, даалгавар-тухай бүр болон 1 дүгээр улирлын байдлаар гарган хүргүүлсэн.
15. Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаварын биелэлт, чиглэлийн хэрэгжилт-20 удаа
16. Улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэгжүүлж байгаа бусад арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт-тухай бүр
17. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн тайлан-сар бүрийн 5-ны дотор
18. Нийслэлийн Засаг даргын албан даалгаварын хэрэгжилтийн тайлан- сар бүрийн 05-ны дотор
19. Нийслэлийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт-1 удаа
20. Байгууллагуудын сарын үйл ажиллагааны тайлан, мэдээ-5 удаа
21. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт -1 удаа
22. Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар зохион байгуулах ажлын төлөвлөөний хэрэгжилт-1
23. НУБГ-ын сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний хэрэгжилт-1 удаа
24. Үйл ажиллагааг үнэлэх үлгэрчилсэн загвар /НЗД-ын 335 дугаар захирамж/-ын биелэлт-1
25. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайлан-2 удаа
26. “Жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг байна” аяны тайлан-1 удаа
27. Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн тайлан-1 удаа
28. “Дэм дэмэндээ” аяны тайлан-1 удаа
29. Сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан-1 удаа
30. Бичиг баримтын аян зохион байгуулсан тайлан-1 удаа
31. Нийслэлийн засаг дарга бөгөөд улаанбаатар хотын захирагчийн 100 хоногт хийсэн ажлын тайлан-1 удаа
32. Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүн амын эрүүл мэндийг хамгаалах бодлогын хүрээнд архи согтууруулах ундааны хор хөнөөлийг олон нийтэд таниулах аяны хэрэгжилтийн тайлан-1 удаа
33. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээ-3

34. НУБГ-ын 7 хоногийн ажлын мэдээ-20 удаа
35. НУБГ-ын 14 хоногт хийсэн ажлын товч тайлан-6 удаа
36. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан-сар бүр/5/ болон улирлаар /1/- НЗДТГ болон УБЕГ-т 6 удаа
37. 2021 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг шинэчлэн гаргасан тухай тайлан-1 удаа
38. Ёс зүйн зөвлөлийн тайлан-1 удаа
39. Нийслэлийн төрийн албаны зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тоон мэдээ-1 удаа
40. Архивын ажлын мэдээ сар бүр -5 удаа
41. УБЕГ-т өдөр бүр хүргүүлдэг мэдээ-162 удаа
42. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд шилжилт хөдөлгөөний мэдээ -1 удаа
43. Нууцын тайлан-1 удаа

***Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын даргын тушаал, шийдвэр, гэрээний төслийг боловсруулж, батлав.***

Тус газраас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 33, хүний нөөцийн чиглэлээр 57, нийт 90 тушаалын төслийг хянаж, нэгдсэн дугаар олгож албажуулан ажилласан байна. Уг тушаалын хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан. Мөн ажил гүйцэтгэх, түрээслэх, гэрээт ажилтан ажиллуулах гэрээ, итгэмжлэгдсэн ажилтантай хийх гэрээний төслийг боловсруулан байгуулав.

Мөн дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдэд 4 удаагийн чиглэл, 2 зөвлөмж боловсруулан хүргүүлсэн.

***Бусад байгууллагатай хамтран ажиллав.***

Тус газар нь 2021 онд өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн халамжийн газар, Нийгмийн даатгалын газар, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Гэр бүл хүүхэд залуучуудын газар”, “Хотын засаглалыг сайжруулах” төсөл, Бүх шатны ерөнхий боловсролын сургуулиуд, Хууль хяналтын болон холбогдох төрийн бүх шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Мөн өөрийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Гэрэгэ системс” ХХК, “Улаанбаатар Буян” ХХК “ Азийн хөгжлийн сан” “Монгол Шуудан” ХХК, “Дэлхийн Зөн” олон улсын байгууллага, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, “Голомт банк”, “Богд банк”, “Хаан банк” зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан.

Уг хамтын ажиллагааны хүрээнд Тус газар нь 2015 оны 10 дугаар сараас MW холдинг ХХК-ний байранд түрээс төлөн үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газарт санал тавьсны үндсэн дээр 2021 оны 3 дугаар сараас Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо, Денверийн гудамж, голден вилл хотхон Монгол банкны D корпуст нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулсан. Ингэснээр ажлын нөхцөл сайжирч түрээсийн төлбөрөө 2 дахин хэмнэсэн.

“Гэрэгэ системс” ХХК-тай хамтран 24 хороонд пос машин байрлуулах, албан хаагчдын цахим цагийн бүртгэлийг нэвтрүүлээд байна.

“Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд Эд хөрөнгийн эрхийн болон Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт зориулан эрх зүйн актуудын эмхэтгэл бүхий гарын авлагыг Азийн Сангийн санхүүжилтээр 500 ширхэгийг хэвлүүлэн албан хаагчдад өгсөн.

“Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан баррель үсэг бүхий гарын авлагын эхийг бэлтгэн хэвлэлтийн шатанд байна.

Улсын бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын хадгалалт, хамгаалалт, нөхцөлийг сайжруулах болон шаардлагатай байгаа өрөө тасалгааны судалгааг гарган дүүргийн Засаг даргын Тамгын газруудад хүргүүлэн ажилласан. Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай дараах байдлаар хамтран ажилласан байна. Үүнд:

**Багануур дүүрэг** дэх улсын бүртгэлийн хэлтэс нь 15м<sup>2</sup> талбай бүхий архивын 1 өрөөг шийдвэрлүүлж, архивын сан хөмрөгийг аюулгүй хадгалах боломжийг бүрдүүлсэн.

**Налайх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь**

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хэлтсийн байр барих газрыг тусгуулсан. /Дүүргийн Засаг даргын газар олгох захирамж хүлээгдэж байна./
2. Хэлтсийн коридорын шалыг дүүргийн ЗДТГ-т хандан солиулсан.
3. Дүүргийн шуурхай штабд хандан албан хаагчдад 500 ширхэг амны хаалт шийдвэрлүүлсэн.

**Баянгол дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:**

1. Нэг цэгийн үйлчилгээний танхимын 10 цонхонд тус бүр нь 270,000 төгрөгийн үнэ бүхий шилэн хаалтыг дүүргийн Засаг даргаар төсөв хөрөнгийг шийдвэрлүүлж байрлууллаа.
2. Нэг цэгийн үйлчилгээний танхимруу орох хаалганд 8,000,000 төгрөгийн үнэ бүхий ариутгалын хаалгыг дүүргийн Засаг даргаар төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэн худалдан авч байрлууллаа.
3. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас албан хаагчдад халдвар хамгааллын хэрэгсэл /маск 1328ш, бээлий 1075ш, бээлий 918, халад 128ш, малгай 160, нүүрний хаалт 50ш цэнхэр спирт 20л/ шийдвэрлүүлж, албан хаагчдад олголоо.
4. Хороодын Засаг дарга нартай хамтран ажиллаж 7 хорооны улсын бүртгэгчийг ажлын өрөө тасалгаатай болгож, ажиллах нөхцлийг нь сайжрууллаа.
5. Дүүргийн 2021-2024 оны төсөвт тус хэлтэст тоног төхөөрөмж худалдан авахад зориулан 100,000,000 /Нэг зуун сая/ төгрөгийн төсвийг суулгуулсан.

**Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс:**

Дүүргийн Засаг даргын Тамгын газраас 6 иж бүрэн компьютерыг хүлээн авч 1,5,8,10,11,12 дугаар хорооны улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгсөн. Уг ажлын хүрээнд дээрх хороон дээр Иргэний шинэчилсэн бүртгэл биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл болон бусад бүртгэлүүдийг хийх нөхцөлийг бүрдүүлж ажилласан.

**Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс:** Дүүргийн Засаг даргын Тамгын газарт албан хэрэгцээнд хэрэглэх тоног төхөөрөмж шаардлага хангахгүй, дутагдалтай байгаа талаарх хүсэлт явуулсны дагуу 2021 оны 03 дугаар 25-нд 1 ширхэг иж бүрэн компьютер хүлээн авсан.

**Чингэлтэй дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс:** Чингэлтэй дүүргийн Тамгын газраас албан хаагч нарын дархлааг дэмжиж бүтээгдэхүүн (нэг сая гурван зуун мянган төгрөгийн үнэтэй) шийдвэрлүүлсэн. Мөн албан хаагч нарт амтны хаалт-1000 ширхэг, халат-20 ширхэг зэргийг шийдүүлсэн байна.

#### **1.4. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон албан

хаагчийг томилох, тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.

2020 оны 348 ХАСХОМ шинэчлэн гаргасан, шинээр томилогдсон 36, их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн 4 албан хаагчийн ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд бүртгэн, хүлээн авсан. Мэдүүлэхээс татгалзсан болон хуулийн хугацаанаас хожимдуулж мэдүүлсэн албан хаагч байхгүй.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шинээр томилогдсон 36 албан хаагчаас “Нууцын баталгаа”-г гаргуулан авсан. Мөн Ерөнхийлөгчийн сонгуулиар ажиллах Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн саналын дагуу 584 итгэмжлэгдсэн ажилтан томилох тухай тушаалыг гаргаж, нууцын баталгаа гаргуулсан. Нийт 620 албан хаагчаас “Нууцын баталгаа” гаргуулсан.

Газрын албан хаагчдын ажлын үнэмлэхийг шинээр хэвлэх, болон сунгах ажлыг хийж байна.

Газрын 200 гаруй албан хаагчийн ажлын үнэмлэхийг шинээр хэвлүүлэх ажлыг зохион байгуулж, албан хаагчдад хүлээлгэн өгч ажилласан.



“Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд тус шинжилгээнд хамрагдсан нийт **323** албан хаагчдын одоо амьдарч байгаа хаягийн мэдээлэл болон хамт амьдарч буй гэр бүлийн гишүүдийн мэдээллийг UB ERP системд бүртгэж, байршууллаа.

“Хүний нөөцийн удирдлага, хяналтын нэгдсэн систем”-д төрийн захиргааны бүх албан хаагчийн мэдээллийг шинэчлэн бүртгэж, баталгаажуулсан.

Дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн ачаалал нэмэгдсэнтэй холбоотойгоор өмнөх онтой харьцуулсан судалгаа болон шийдвэрлэх арга замын судалгааг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор “Гэрэгэ системс” ХХК-тай хамтран албан хаагчдын ажилдаа ирсэн явсан цагийг QR код ашиглан бүртгэх ажлыг эхлүүлсэн. Уг ажлын хүрээнд 4 хэлтсийн 41 албан хаагчийг туршилтын журмаар хамруулаад байна.

## **1.5. СУРГАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД**


Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан “Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын сургалтын төлөвлөгөө”-г баталж, 63 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 2497 ажилтан, албан хаагч хамруулсан. Үүнд:

- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газраас-10 удаагийн сургалтаар-169
- ❖ Нийслэл дэх улсын бүртгэлийн газраас-24 удаагийн сургалтаар-1856
- ❖ Бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан 14 удаагийн сургалтанд 324 албан хаагч тус тус хамрагдсан байна.

Нийслэл дэх улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан томоохон сургалтуудаас дурьдвал:



- ❖ 1,2,3-р сард өргөдөл, гомдолд нэр дурьдагдсан 27 албан хаагч хамруулан 2 удаагийн сургалт (“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ ба байгууллагын үйлчилгээний стандартын тухай мэдлэг” сэдэвт) сургалт;
- ❖ Нягтлан бодогч, няравуудыг чадавхжуулах танхимын сургалт (ахлах нягтлан бодогч нарыг хамруулсан);
- ❖ Тус газарт шинээр томилогдсон төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад “Танилцах сургалт”(Сургалтанд 2020 оны 4 дүгээр улирлаас хойш шинээр томилогдсон нийт 30 албан хаагч хамрагдсан байна);
- ❖ “Хороод дахь улсын бүртгэгч нарыг чадавхижуулах” цуврал сургалтыг 2 дугаар сарын 25-ны өдрөөс 4 дүгээр сарын 23-ны өдрийн хугацаанд “Хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим үйлчилгээний талаар, мэдээлэл олгох, цаашид анхаарах асуудал мэдлэг олгох” сэдвээр 11 удаа (Нийслэлийн хороод дахь улсын бүртгэгч нарын 97.6 хувь буюу 337 албан хаагч хамрагдав);



- ❖ Монгол бичгийн цуврал сургалтыг зохион байгуулж 16 албан хаагч хамрагдав.



Энэ оны эхний хагас жилийг 2020 оны мөн үетэй харьцуулбал сургалтын тоо 47-оор, албан хаагчийн тоо 773-аар ихэссэн үзүүлэлттэй байна.

Цаашид сургалт явуулах арга хэлбэрийг улам боловсронгуй болгох, ялангуяа цахим хэлбэрээр сургалт зохион байгуулах дэд бүтцийг сайжруулах, ажилтнуудыг боломжтой үедээ өөрийгөө боловсруулах, хөгжүүлэх боломж бүхий сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалтын хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлох, ажилтнуудыг ялангуяа шинэ ажилтнуудыг мэргэшүүлэх, аргачлал бүхий гарын авлага материалаар хангах зорилт тавин ажиллаж байна.

### **1.6 САНХҮҮ, АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Газрын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Олон улсын стандартад нийцүүлэн батлагдсан маягт зааврын дагуу хөтлөх, газрын болон дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтсийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

#### **Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:**

- ❖ Байгууллагын 1-р улиралын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.
- ❖ Нийгмийн даатгал, хүн амын орлогын албан татвар, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг тус тус хугацаанд нь хүргүүлсэн.
- ❖ Санхүүгийн тайлангийн аудитыг Их наяд аудит ХХК-аар хийлгэж, “ЗӨРЧИЛГҮЙ” дүгнэлт авсан.
- ❖ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг цаг хугацаанд нь хоцрогдолгүй оруулсан.
- ❖ УБЕГ-ын тайлан, мэдээ гаргах журмын дагуу сар бүр тайланг дараа сарын 2-ны дотор хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.
- ❖ Ирэх оны төсвийн саналыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлэхээр санал авч байна.

#### **Байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасалдалгүй ханган ажиллах хүрээнд:**

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийг үр бүтээлтэй зарцуулах, хуваарилах, төлөвлөх ажлыг хийж гүйцэтгэсний үр дүнд төсөв /2693.1/ хэтрээгүй, төсвийн хуваарьт 2 удаа өөрчлөлт оруулж өр авлагагүй, төсөв нэмэгдүүлэх санал 2 удаа өгсөнөөр нүүлгэлтийн зардалд 70,0 сая төгрөг шийдвэрлүүлж ажлыг гүйцэтгэсэн. УБЕГ-аас 135 ширхэг 234,3 сая төгрөгийн өртөгтэй 75,4 сая төгрөгийн элэгдэлтэй компьютер канон принтер хүлээн авсан.Багануур дүүргийн Засаг даргын хөрөнгө оруулалтаар 19,6 сая төгрөгийн үнэтэй Приус 30 маркийн авто машин шийдвэрлүүлсэн. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалтаар 5,4 сая төгрөгийн 2ш компьютер ,2ш принтер шийдвэрлүүлсэн.

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг тогтмол төвлөрүүлсэн.

#### **2021 оны эхний 5 сарын байдлаар дараах орлогыг төвлөрүүлэн ажилласан байна.**

-	Хугацаа	Орлого, зардлын зүйл анги	Үйлчилгээний төрөл	Мөнгөн дүн /өссөн дүнгээр/
1	2021 оны 5 дугаар сарын байдлаар	Улсын төсөвт	Үйлчилгээний орлого	4 тэрбум
2		Орон нутгийн төсөв	Торгууль шийтгэврийн орлого	290,3 сая

			Тэмдэгтийн хураамж	103,1 сая
			Үл хөдлөх хөрөнгийн татвар	3,5 тэр бум

**Улс, орон нутгийн сонгуулийн санхүүжилтийг батлагдсан зардлын ангиллын дагуу зарцуулах ажлын хүрээнд**

- ❖ Ерөнхийлөгчийн сонгуулийн 499,2 сая төгрөгийн зардлыг УБЕГ-ын даргын баталсан А/176 дугаар тушаалын дагуу зарцуулж тайлагнасан
- ❖ Батлагдсан төсвийн хүрээнд сар улиралын хуваарь гарган ажилласан.
- ❖ Сар улирлын үйл ажиллагаатай холбоотой тоо мэдээг үнэ зөв гаргаж тайлагнасан Төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүр гаргаж хэтрэлт гаргаагүй ажилласан бөгөөд зарим хэмнэлттэй зардлуудаас дутагдаж байгаа зардалд шилжүүлэн тухай бүрт нь арга хэмжээ авч ажилласан.

**Үндсэн хөрөнгө, бараа материалын орлогыг үнэн зөв хүлээн авч зарцуулалтанд хяналт тавьж ажиллаа.**

Орлого /үндсэн хөрөнгө/		
УБЕГ-аас	Багануур дүүргийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт	ХУД-ын хөрөнгө оруулалт
4 нэр төрлийн 135 ширхэг 234,3 сая төгрөгийн өртөгтэй 75,4 сая төгрөгийн элэгдэлтэй	19,6 сая төгрөгийн үнэтэй Приус 30 маркийн авто машин	2 нэр төрлийн 4 ширхэг 5,8 сая төгрөг компьютер принтер

**Үндсэн хөрөнгийн орлого:** Улсын бүртгэлийн ерөнхий газраас 10 нэр төрлийн 158 ширхэг 157,1 сая төгрөгийн үнэтэй 102,9 төгрөг элэгдэлтэй, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалтаар 7 нэр төрлийн 70 ширхэг 68,2 сая төгрөгийн орлого, Чингэлтэй дүүргийн хөрөнгө оруулалтаар 9 нэр төрлийн 22 ширхэг 39,4 сая төгрөгийн УБЕГ-аас 135 ширхэг 234,3 сая төгрөгийн өртөгтэй 75,4 сая төгрөгийн элэгдэлтэй компьютер канон принтер хүлээн авсан. Багануур дүүргийн засаг даргын хөрөнгө оруулалтаар 19,6 сая төгрөгийн үнэтэй Приус 30 маркийн авто машин шийдвэрлэсэн. ХУД-ын ЗДТГ-ын хөрөнгө оруулалтаар 5,4 сая төгрөгийн 2ш компьютер ,2ш принтер орлого хүлээн авч данс бүртгэлд бүртгэн ажиллав.

Зарцуулалт, хуваарилсан /үндсэн хөрөнгө/			
Акталж ашиглалтаас хассан	Дүүрэгт шилжүүлсэн	Нэгдсэн төвд шилжүүлсэн	Бусад дотоодод шилжүүлсэн
Аклагдах хөрөнгийн жагсаалт гаргаж өмч хамгаалах зөвлөлд оруулж байна.	23 нэр төрлийн 154 ширхэг 256,8 сая төгрөг		6 нэр төрлийн 30 ширхэг 28,7 сая төгрөг

**Орлого/ бараа материал/**

УБЕГ-аас			Урсгал төсөв			Сонгуулийн санхүүжилт		
68 нэр төрлийн 201375ширхэг төгрөг	56,6 сая		91 нэр төрлийн 52214ширхэг	78,8сая төгрөг		32 нэр төрлийн ширхэг	19190 сая төгрөг	

### Зарцуулалт, хуваарилсан /бараа, материал/

Акталж ашиглалтаас хассан	Үйл ажиллагаанд	Сонгуулийн зардалд	Бусад дотоод шилжүүлсэн
13 нэр төрлийн 1783 ширхэг 468,2 мянган төгрөг	85 нэр төрлийн 306685 ширхэг 83,5 сая төгрөг	32 нэр төрлийн 19190 ширхэг 55,5 сая төгрөг	85 нэр төрлийн 410120 ширхэг 116,3 сая төгрөг

Ажилчин албан хаагчдын цалин хөлс, урамшуулалыг цаг хугацаанд нь бодож олгож цагийн бүртгэл бусад тооцооллод хяналт тавьж ажиллаа. Итгэмжлэгдсэн ажилтануудын байгуулсан гэрээний дагуу урамшуулалын тооцож холбогдох журмын дагуу татвар НДШ суутган ажилласан.Цалингийн сангийн төсөвт судалгаа хийж УБЕГ-т хүргүүлсэн.

Үзүүлэлт сая.төг	Батлагдсан төсөв	Нэмсэн	Нийт төсөв	Олгосон
Цалин хөлс	2472,1		2472,1	2472,1
НДШ	311,7		311,7	355,1
Нийт	4591.7	513.0	5104.7	5085.5

Бусад ажлын чиглэлээр:

- ❖ Байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээг үнэн зөв тооцож гаргаж анхан шатны баримт материалыг нэг стандартанд оруулсан
- ❖ Эхний 4 сарын байдлаар эд хөрөнгийн бүртгэлийн тоо мэдээг програмын сантай тулгаж зөрчилтэй мэдээллийг талаар хэлтэс тасгийн дарга нарт зөвлөмж өгч ажиллаа.
- ❖ Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн хэрэгжилтийг хангаж 2020 оны 9 дүүрэг нэгдсэн төвийн иргэний бүртгэлийн үйлчилгээтэй холбогдсон төлбөрийн баримтыг шалгасан.
- ❖ Газрын нүүлгэлт, засвар үйлчилгээтэй холбоотой ажлуудыг чиг үүргийн дагуу гүйцэтгэж, УБЕГ-аас 70,0 сар төгрөг шийдвэрлүүлээ.
- ❖ Улсын бүртгэлийн үйлчилгээний үнэ хураамжинд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан бэлтгэл ажиллагаа, заавар зөвлөмж өгч ажилласан.

## 1.7 АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

### 1.7.1 Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Баримт бичгийн шийдвэрлэлт болон бусад мэдээллийн эрэлт хайлтыг шуурхай болгох үүднээс газарт ирсэн баримт бичгийг “Албан хэрэг хөтлөлтийн E-DOC програм”-д бүртгэн компьютерийн санамжид оруулан ажиллалаа.

- 1.1 Тайлангийн хугацаанд **3811** албан бичиг хүлээн авч edoc програмд бүртгэснээс хариутай бичиг **1352** байна. Дээрх албан бичгээс 3030 албан бичиг нь албан хэрэг хөтлөлтийн edoc систем хэрэглэгч байгууллагад, 36 нь нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд бүртгэгдэж цахим хэлбэрээр ирсэн бол үлдсэн 781 албан бичгийг байгууллага дээр скайнердаж цахимжуулсан байна. Мөн able програмд нийт 13 албан бичиг бүртгэгдэж шилжүүлэн шийдвэрлэсэн. Нийслэлийн онцгой комиссоос 13, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 92, дээд газраас ирсэн тушаал 73 байна. Албан бичгийн шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд ирсэн бичгийн шийдвэрлэлт 94.88%, шийдвэрлэлтийн дундаж хоног 12.66 байна.
- 1.2 Мөн хугацаанд нийт **35** тушаал / үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 11, хүний нөөцийн чиглэлээр 24 /, edoc-т **391**, able-т **1** албан бичгийн төслийг холбогдох ажилтнуудаас хүлээн авч, удирдлагаар баталгаажуулан хэвлэмэл хуудсанд буулган албажуулан, нэгдсэн дугаар олгож явуулсан. Эдгээрээс Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн програмаар илгээж бусад албан бичгүүдийг дугтуйлан хаяглаж, шуудангаар холбогдох газарт нь хүргүүлсэн.
- 1.3 Газрын албан хэрэг хөтлөлтийн талаарх ирсэн явсан бичгийн тайланг 7 хоног бүрээр, баримт бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, баримт бичгийн эргэлтийн мэдээг 14 хоног тутамд гарган ажилласан.

**Байгууллагын архивын чиглэлээр:**

а/ 2020 онд хөтлөгдсөн байнга хадгалах, 70 жил хадгалах, түр хадгалах хадгаламжийн нэгжийг батлагдсан хуваарийн дагуу холбогдох хэлтэс, нэгжүүдээс хүлээн авч, архивт нөхөн бүрдүүлэлт хийлээ.

б/ Архивт баримт шилжүүлэх үед хадгаламжийн нэгжид нягтлан шалгалт хийсэн.

в/ Хүлээн авсан хадгаламжийн нэгжид хадгалах хугацааны ангиллаар данс бүртгэл үйлдсэн.


г/ Архивын цэвэрлэгээ, үйлчилгээ хуваарийн дагуу тогтмол хийгдэж байна.

д/Байгууллагын архивын чийг, дулааныг өдөр тутам тогтмол хэмжиж, тэмдэглэл хөтөлж байна.

Албан хаагчдын албан хэрэгцээнд архивын баримт ашиглуулахдаа бүртгэлийг тогтмол хөтөлж байна.

Хэвлэмэл хуудсны тайланг хүлээн авч, хүчингүй болсон хэвлэмэл хуудас байхгүй байна.

Дотоод хэлтсийн ажилтнуудын гадуур ажиллах ажилтны бүртгэлийн дэвтрийг өдөр тутам хөтөлж байна.



Энэ оны эхний хагас жилийг 2020 оны мөн үетэй харьцуулахад ирсэн, явсан бичиг, хариутай бичиг буурсан буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь цар тахлын нөхцөл байдлаас болж хөл хорио тогтоож байгууллагууд хэвийн үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсонтой холбоотой.

### 1.7.2 Өргөдөл гомдол шийдвэрлэлт:

Тус газар нь иргэн, хуулийн этгээдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд хариу өгөх жишиг тогтоох үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд тус газарт иргэн, хуулийн этгээдээс нийт 101 өргөдөл, гомдол, хүсэлт, санал ирсэн байна.

Үүнд:


- Гомдол–60
- Хүсэлт – 35
- Санал – 4
- Цуцлах хүсэлт-2 тус тус ирүүлсэн байна.

#### Гомдол:


Нийт ирсэн гомдлыг агуулга болон эзлэх хувийг авч үзвэл

- Байгууллагын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалттай холбоотой – 12 буюу 21 хувь
- Ажилтны харилцаа ёс зүйтэй холбоотой – 21 буюу 35 хувь
- Эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой – 11 буюу 18 хувь
- Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой -16 /цахим архив– 5 буюу 8 хувь, иргэний үнэмлэх – 2 буюу 3 хувь, шилжилт хөдөлгөөн – 9 буюу 15 хувь/-г ийг тус тус эзэлж байна.

Гомдлын агуулгыг графикаар харуулбал :




Гомдол ирүүлсэн байдлыг дүүрэг бүрээр харуулбал:






Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс




- Байгууллагын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалттай холбоотой - 4
- Ажилтны хариуцлага, ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой - 7
- Цахим архив - 2
- Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой - 2

Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс




- Ажилтны хариуцлага, ёс зүй, харилцаа, хандлагатай - 3
- Цахим үнэмлэхтэй холбоотой - 1
- Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой - 3

Сонгинохайрхан дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс 7%




- Байгууллагын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалттай холбоотой - 1
- Ажилтны хариуцлага ёс зүй, харилцаа, хандлагатай - 3
- Эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлтэй холбоотой - 3
- Цахим үнэмлэхтэй холбоотой - 1
- Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой - 4

Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс




- Байгууллагын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалттай холбоотой - 4
- Ажилтны хариуцлага ёс зүй, харилцаа, хандлагатай - 2
- Эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлтэй холбоотой - 4
- Цахим үнэмлэхтэй холбоотой - 1

Чингэлтэй дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс




- Байгууллагын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалттай - 1
- Ажилтны хариуцлага, ёс зүй, харилцаа, хандлагатай - 1

Налайх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс



- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой - 1



Нийт ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100 хувь, хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол байхгүй.

**Авч хэрэгжүүлсэн сайжруулалтын арга хэмжээ:**

1. “Ажилтны хариуцлага, ёс зүй, харилцаа, хандлага”-тай холбоотой 21 өргөдөл гомдол ирсэн нь тухайн улиралд ирсэн нийт 60 өргөдөл, гомдлын 35 хувийг эзэлж байгаа өргөдөл гомдлыг багасгах, бүртгэгч нараа чадавхжуулахын тулд :

**1.1 Сургалтанд хамруулах**

“Өргөдөл, гомдолд нэр нь дурьдагдсан ажилтнуудад “Төрийн албан хаагчийн ёс зүй ба байгууллагын үйлчилгээний стандарт” сургалтыг 2 удаа зохион байгуулснаар 27 ажилтан хамрагдан тодорхой кейсүүд дээр дадлага ажил хийв.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нийслэлийн сургалт, судалгааны төвд хүсэлт гаргасны дагуу тус төвтэй хамтран 05 дугаар сарын 04-13-ны өдрүүдэд нэгжийн удирдах албан тушаалтан /ТЗ-7-оос дээш /- нуудад “Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албан хаагчийн гадаад төрх бүрдүүлэлт” сэдвээр 2 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 90 гаруй ажилтанг хамруулсан. Нийт 117 ажилтан хамрагдсан

**1.2 “ДАТА” бааз үүсгэж, холбогдох арга хэмжээг авах**

Өргөдөл, гомдлын агуулга, харьяалал болон холбогдох мэдээлэл бүхий “ДАТА” үүсгэж, шаардлагатай тохиолдолд хуулийн хүрээнд холбогдох арга хэмжээг авах санал хүргүүлэх

2. “Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой” өргөдөл, гомдол нийт өргөдлийн 21 хувийг эзлэж байна.

**2.1 Мэдээллээр хангах**

Сар бүр Газрын даргын шуурхай хуралдаанд тухайн сарын “Өргөдөл, гомдлын сарын тайлан” болон иргэд, харилцагчдаас ирүүлсэн санал, хүсэлтийг танилцуулж, тулгамдсан асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар нэгдсэн байр суурьтай болох

Байгууллагын албан ёсны цахим сайтад “Өргөдөл, гомдлын сарын тайлан”-г сар бүр тогтмол байршуулж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажиллах

Богиносгосон цагаар ажиллах г.м цаг үеийн яаралтай гаргасан шийдвэрүүдийн иргэд, харилцагчдад шаардлагатай мэдээллийг ил тод, түргэн шуурхай мэдээлэх

3. “Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээтэй” холбоотой гомдол нийт 12 ирсэн бөгөөд 26 хувийг эзлэж байна. /Цахим архив, Шилжилт хөдөлгөөн, Цахим үнэмлэх/

2021 оны 05 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын Ахлах мэргэжилтэн Т.Байгалмаа “Цахим архив ашиглах, лавлагаа олгох нь” сэдвээр дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Уг сургалтыг 4 удаа зохион байгуулж, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, иргэний бүртгэлийн улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нийт 180 албан хаагч хуваарийн дагуу хамрагдаж, “Цахим архив”- ыг хэрхэн бүрэн ашиглах ур чадварт суралцав.

4. “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой” нийт 11 өргөдөл, гомдол ирсэн байна.

4.1 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын ахлах, улсын бүртгэгч нарыг чадавхижуулах, бүртгэл хөтлөх болон цахим системийн боловсруулалтад анхаарах




асуудлуудын талаар зөвлөмж, чиглэл өгөх цахим сургалтыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулж, уг сургалтанд “Нотариатчийн мэдээлэл нийлүүлэх үйл ажиллагаа, Мэдээлэл шалгах системд бүртгэх нь” сэдвээр ЭХЭУБГ-ын Ахлах мэргэжилтэн З.Ганцэцэг, “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаатай холбоотой анхаарах асуудал” сэдвээр ЭХЭУБГ-ын Улсын ахлах бүртгэгч Э.Отгонтунгалаг нар хичээл зааж, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн 15 албан хаагчид хамрагдсан байна.

4.2 УБЕГ-ын Тамгын газар, Хяналт шалгалт, Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрууд хамтран эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх талаар мэдээлэл олгох цахим сургалтыг зохион байгуулсан байна. Дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн 15 албан хаагч хамрагдсан байна.

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийг сайжруулах зорилгоор ажлын төлөвлөгөө боловсруулан, хуулийн хүрээнд шийдвэрлэлтийн хүрээнд сайжруулалтын арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ERP.Ulaanbaatar.mn системд тус газрын дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдийг байгууллагын дотоод нэгжүүдэд шилжүүлэх хүсэлт хүргүүлэв. Энэ нь өргөдөл, гомдол санал хүсэлтийг шийдвэрлэх шат дамжлагыг бууруулах ач холбогдолтой байна.

**Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног 12 цаг 29 минут байна.** Энэ нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаанаас бага хугацаанд шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.



2021 оны эхний хагас жилийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 66 өргөдөлөөр буурсан үзүүлэлттэй байна. Мөн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоногоор багассан үзүүлэлттэй байна.

### **1.8.МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

#### **Мэдээллийн сан, программ хангамжийн үйл ажиллагаа.**

Газрын тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, ашиглалтад хяналт тавих, мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.

Тоног төхөөрөмжийн, програм болон сүлжээний аюулгүй байдлыг тасалдуулахгүй ажиллах хүрээнд тоног төхөөрөмжийн засвар гэмтлийг тухай бүр оношлон шуурхай засварлаж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар хороодын бүртгэгч нар улсын бүртгэлийн нэгдсэн санд хандах боломжтой болж сүлжээнд холбогдсон. Шинээр байгуулагдсан Сонгинохайрхан дүүргийн 11 /32-43/ хороо, Налайх дүүргийн наймдугаар хороо, хотоос алслагдсан хороо болох Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, Мөн Баянзүрх, Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст 4G төхөөрөмжийг суурилуулж лацдан улсын бүртгэгч

нарт хүлээлгэн өгсөн. Уг төхөөрөмжийг суурьлуулснаар шилэн кабель холбогдох боломжгүй, улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээ орох боломжгүй байсан хороодыг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээтэй болгож иргэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцлөөр хангагдсан.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын <https://erp.ulaanbaatar.mn/>- системээр хүнийн нөөцийн удирдлага, утасны жагсаалт, цаг бүртгэл, мэдээ мэдээлэл, ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгавар, олон нийтийн сүлжээ, тайлан судалгаа, өргөдөл гомдол, үндсэн хөрөнгө бүртгэл, үйл явдал, судалгаа авах, байгууллагын архив, албан хэрэг хөтлөх, дотоод мессенжер гэм мэт маш өргөн боломжтой цогц системийг албан хаагч нарт хандах эрхийг тохируулан бүртгэл хийж байна.

## **1.9 БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ СУРТАЛЧИЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

### **Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал**

Байгууллагын ил тод нээлттэй, шуурхай хариуцлагатай байдлыг хангаж, төр иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчилж мэдээлэх, иргэдийн санал бодлыг сонсох, “Нээлттэй хаалганы өдөр”, “Мэдээллийн цаг”, бүртгэлийн “Ёслолтой арга хэмжээ”, иргэдэд чиглэсэн бусад үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ил тод, нээлттэй, хариуцлагатай, хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилтуудыг тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 411 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам батлах тухай”, 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу байгууллагын эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл болон байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, төр засгийн бодлого шийдвэртэй холбогдсон мэдээ, мэдээллийг “Мэдээллийн самбар”, цахим дэлгэц, байгууллагын болон хэлтэс нэгжийн цахим хуудас, фэйсбүүк хуудсанд бүрэн байршуулж, мэдээллийг тухай бүрт шинэчлэн ойлгомжтой байдлаар байршуулсан.

- ❖ Байгууллагын хэмжээнд иргэдийг цагийн хуваарьгүйгээр хүлээн авч, санал хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна. Газрын нийт албан хаагчид болон өргөдөл, гомдол хүлээн авах мэргэжилтний мэдээллийг газрын цахим хуудсанд нээлттэй байршуулан, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн төлөвлөлтийн систем /ERP/-д цахим өргөдөл, гомдлын дэд системийг ашиглан, Засгийн газрын 11-11 төв, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд, Шуурхай удирдлага, зохицуулалтын төв, [www.ub1200.mn](http://www.ub1200.mn) цахим хуудас, smart UB, Clean UB аппликейшн, 1800-1200, бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 тусгай дугаарын утас, газрын 7777-1890 болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон тус газрын веб хуудас, хэлтэс нэгжүүдийн ажлын байр, иргэдээс санал хүсэлт авах хайрцаг, дэвтэр зэрэг эх сурвалжаар иргэд, байгууллагаас 101 өргөдөл хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэн ажилласан.
- ❖ Дүүргийн зарим чиг үүргийг хороодод үе шаттайгаар шилжүүлэх арга хэмжээний хүрээнд иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээ, иргэний үнэмлэх дахин олголт, төрсний бүртгэл, гэрлэлтийн бүртгэл, гэрлэлт цуцлалтын бүртгэл, бүх төрлийн лавлагаа зэрэг иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг шилжүүлснээр иргэдэд засаг захиргааны харьяалал харгалзахгүйгээр үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна. Ингэснээр:
  - Иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг зөвхөн 1 дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн 9 цэгээс авдаг байсан бол хороодод шилжүүлсэнээр

нийт 50 цэгээс үзүүлж үйлчилгээний хүртээмж нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулсан.

- Хороодоос үзүүлж буй бүртгэлийн үйлчилгээ нэр төрөл 40 хувиар нэмэгдсэн.
- Иргэдийн үйлчилгээ авах цаг хугацаа болон зардлыг хэмнэсэн.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг тэгш авах боломжийг бүрдүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан баррель үсэг бүхий гарын авлагыг хэвлүүлэхээр азийн хөгжлийн сангаас хөрөнгийг нь шийдвэрлүүлж, хэвлэлтийн шатандаа явж байна.

**Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал:** Энэ хүрээнд <https://www.niislel@burtgel.gov.mn> байгууллагын цахим хуудаст хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан тухай тушаал, Байгууллагын бүтэц, орон тоог баталсан тушаал, баталсан орон тоонд ажиллаж байгаа албан хаагчдын мэдээлэл зэрэг хүний нөөцтэй холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

Байгууллагын шилэн дансанд хүний нөөцтэй холбоотой мэдээ, мэдээллийг сар бүрийн эхний 7 хоногийн дотор буюу тогтоосон хугацаанд оруулсан.

**Гурав. Төсөв санхүүгийн ил тод байдал:** 2020 оны НУБГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, НУБГ-ын 2020 оны эхний хагас санхүүгийн тайланг тус тус байршуулав.

Шилэн дансанд нийт 5 удаа 56 мэдээллийг байршуулсан. Хугацаа хоцроож тайлагнасан болон огт оруулаагүй мэдээлэл байхгүй.

**Байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан байдал:**

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээлэл болон хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг бүхий л арга хэлбэрээр шуурхай хүргэхийн зэрэгцээ бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд:

- ❖ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, газрын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.
- ❖ Нийслэл болон дүүргүүд дэх Улсын бүртгэлийн газар, хэлтсүүд өөрсдийн Нүүр ном /FACEBOOK/ хуудсанд нийт 157 удаа шинэ мэдээ, мэдээлэл оруулж, нийлбэр дүнгээрээ 43134 харилцагч эдгээр хуудсануудад зочилж, улсын бүртгэлийн хууль тогтоомж, үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл шинээр авсан байна.
- ❖ Ёслолтой бүртгэлийг Сонгинохайрхан, Хан-уул, Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүд нийт 53 хосын Гэрлэсний бүртгэлийг ёслолтойгоор хийж дээрх арга хэмжээнд 142 харилцагч оролцсон байна.
- ❖ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах хэлтэстэй хэрхэн хамтран ажиллах талаар санал хүргүүлэв.
- ❖ Нийслэл дэх улсын бүртгэлийн хэлтэс шинэ байранд шилжин ирсэнтэй холбоотойгоор тус газрын “Мэдээллийн самбар”-ыг байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан байхуйцаар мэдээллийг шинэчлэв.
- ❖ Мэдээллийн самбар”-ын агуулгыг үлгэрчилсэн байдлаар гаргаж, хэлтсүүдэд газрын даргын чиглэлээр хүргүүлэв.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд иргэдийг мэдээллээр

хангах үүднээс МҮОНТ-ийн “Олон нийтийн цаг” нэвтрүүлэгт улсын бүртгэгч С.Баасандулам, Ц.Урансайхан нар оролцож иргэний улсын бүртгэлийн талаар ярилцлаа.



2021 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Чингэлтэй дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Мөнхгэрэл fm 83.5-ын шууд эфирээр ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох талаар иргэдэд мэдээлэл өгч оролцсон.

**Улсын бүртгэлийн байгууллагын “Үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд:**

Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, өдөр тутмын хяналт тавих, тайлагнах зэрэг чиг үүргийг тухайн нэгжийн хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч нар хэрэгжүүлж, сар бүр НУБГ\_СТ\_1, НУБГ\_СТ\_2 маягтаар хэрэгжилтийг дүгнэж хэвшлээ.

Дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдээс “ДҮГНЭХ ХУУДАС”-аар сар бүр ирүүлсэн үнэлгээг улирлаар нэгтгэхэд дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдийн дундаж 92 хувьтай, НТҮНТ-үүдийн дундаж 94 хувь байна.

Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд нилээдгүй ажлыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

1. 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс 1 дүгээр сарын 29-ны өдрүүдэд дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс, НТҮНТ, хороодод батлагдсан удирдамжийн дагуу дараах чиглэлээр ажиллав. Удирдамжийн дагуу Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилт, Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлт, e.doc програм хангамжийн ашиглалт, зөрчлийн мэдээлэл, Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг шалгаж, тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч гүйцэтгэлийг газрын даргад “Илтгэх хуудас”-аар танилцуулсан байна.



2. Газрын даргын баталсан “шалган-туслах” удирдамжийн дагуу Баянгол, Баянзүрх



дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн 32 хорооны улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. Дээрх ажлын хэсэг хороод дахь улсын бүртгэгчийн ажлын байрны нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, сүлжээний аюулгүй байдал зэрэгтэй танилцаж, шинээр томилогдсон хороодын Засаг дарга нарт бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар харилцан санал солилцож, бүртгэгч нарт тухай бүр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөн ажиллав. Ажлын хэсэг гүйцэтгэлээ илтгэх хуудсаар газрын даргад танилцуулсан.



3. Тайлангийн хугацаанд нийт 3 удаа нэгжүүдэд чиглэл хүргүүлсэн байна.

Дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдийн “2020 оны үйл ажиллагааны тайлан”-д дүн шинжилгээ хийн, харилцагчийн үйлчилгээний чиглэлээр өгсөн үнэлгээ, цаашид анхаарах асуудлуудаар хэлтсийн дарга нарт чиглэл хүргүүлэн ажиллав.

Улс орны хэмжээнд цар тахал гарч Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын хөл хорио тогтоосон хүндрэлтэй үед иргэд харилцагчид утсаар “ЛАВЛАХ” үйлчилгээ авахыг чухалчилж байгаа бөгөөд үйлчилгээ үзүүлэхдээ “Байгууллагын үйлчилгээний стандарт”-ын 8 дугаар зүйлд заасан “ЛАВЛАХ” үйлчилгээний алхмуудыг хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмж, мөн утсаар лавлах үйлчилгээ өгөхөд шаардлагатай “САНАМЖ”-ийн талаар 2 удаа чиглэл хүргүүлсэн байна.

4. Улсын бүртгэлийн Ерөнхий газарт УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН БРЕНДБҮҮК БҮТЭЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА-тай байгаа тухай саналыг албан бичгээр хүргүүлэв.

5. Шинээр томилогдсон төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад “Танилцах сургалт”-ыг 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж, “Авилгаас урьдчилан сэргийлэх болон Төрийн нууцын тухай хуулийн хэрэгжилт”, Газрын бүтэц, чиг үүрэг, танилцуулга, “Төрийн албан хаагчийн ёс зүй ба байгууллагын үйлчилгээний стандарт” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.

6. Удаан хугацаагаар хөл хорио тогтоосон, 6 хувийн хүүтэй ипотекийн болон Засгийн газрын эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөрийн эхний шат болох ажлын байр хадгалахад дэмжлэг үзүүлэх 3 хувийн зээл олгох болсонтой холбоотойгоор эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ авах иргэдийн ачаалал, гомдол санал харьцангуй ихэссэнтэй холбоотойгоор холбогдох албан тушаалтнууд Мишээл, Дүнжингарав НТҮН дэх тасгуудад ажиллаж нэгжийн болон улсын бүртгэгч нарын ажлын ачаалал ихэссэн байдлын судалгаа авч, дата анализ хийн холбогдох саналын хамт газрын даргад танилцуулан, Улсын бүртгэлийн ерөнхий газарт санал хүргүүлэв.

### **ХОЁР.УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**



#### **2.1.ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЧИГЛЭЛЭЭР:**

Нийслэлийн хэмжээнд 2021 оны 5 дугаар 25-ны байдлаар **215248** иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг газар, 9 дүүрэг болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, хороодоор хүргэн ажилласан байна. Үүнд:

- ❖ Төрсний бүртгэл-14380
- ❖ Гэрлэлтийн бүртгэл-2492
- ❖ Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-625
- ❖ Үрчлэлтийн бүртгэл-141
- ❖ Овог эцэг /эх/-ийн нэр,нэр өөрчлөлтийн бүртгэл-382

- ❖ Эцэг тогтоолтын бүртгэл-279
- ❖ Нас баралтын бүртгэл-3602
- ❖ Засвар өөрчлөлт-259
- ❖ Төрсний гэрчилгээ дахин олголт-17566
- ❖ Гэрлэсний гэрчилгээ дахин олголт-2684
- ❖ Нас барсны гэрчилгээ дахин олголт-3602
- ❖ Аймаг хотоос бүрмөсөн шилжин-8141
- ❖ Хот доторх шилжилт хөдөлгөөн-36215
- ❖ Иргэний үнэмлэх олголт /шинэ/-7020
- ❖ Иргэний үнэмлэх олголт /хугацаа сунгалт/-18207
- ❖ Иргэний үнэмлэх олголт /дахин/-16666
- ❖ Үндэсний энгийн гадаад паспорт олголт-20399
- ❖ Лавлагаа олголт-62588

Иргэний бүртгэлийн чиглэлээр үзүүлсэн үйлчилгээ 2020 оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй гадаадад зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай холбоотой үндэсний энгийн гадаад паспорт олголтын бүртгэлийн олголт 4 дахин буурсан буюу эрс багассантай холбоотой. Мөн сонгуультай холбоотойгоор шилжилт хөдөлгөөний бүртгэлийн үйлчилгээний тоо багассан байна.



2020 оны мөн үетэй харьцуулахад бүртгэлийн тоо ба 20 орчим хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үндэсний энгийн гадаад паспорт олголт 50 хувиар багассан үзүүлэлттэй байна.

**Бичиг баримтжуулсан ажлын талаар:** Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоол Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/487 дугаар захирамжийг үндэслэн Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгмийн олон талт үйлчилгээнд хамруулах зорилгоор иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах ажлын хүрээнд Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, ШШГЕГ-ын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан хөдөлмөр хийлгэх газар зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан.

- ✓ Багахангай дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь 2021.03.29-ны өдөр ШШГЕГ-ын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан хөдөлмөр хийлгэх газрын 2 иргэнд /дахин-1, сунгалт-1/,



- ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 421 дүгээр нээлттэй хорих ангийн 28 хоригдлын цахим үнэмлэхийн сунгалт болон дахин олголтын бүртгэлийг тус хорих ангид очин хийж иргэний үнэмлэхийг олгов.
- ✓ Баянзүрх дүүргийн Улаанзагалмай нийгэмлэгтэй хамтран дүүргийн зорилтот бүлгийн 31 иргэнийг, Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын ажлын албатай хамтран 31 иргэнийг, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газартай хамтран дүүргийн зорилтот бүлгийн 3 иргэнийг, нийт 65 иргэнийг бичиг баримтжуулав.
- ✓ Хан-Ууд дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс аяны хүрээнд 4 дүгээр хорооны Засаг даргатай хамтран ажиллаж, 23 иргэний бичиг баримтжуулах санхүүжилтийг олгосон.

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтарч зорилтот бүлгийн бичиг баримтгүй иргэдийг бичиг баримтжуулах аяныг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн А/93 дугаар захирамжаар 16 200 000 төгрөгийг дүүргийн төсвөөс гаргуулж 875 иргэнийг бичиг баримтжуулсан.



**Тайлангийн хугацаанд нийт 993 иргэний бичиг баримтжуулан ажиллалаа.**

### **2.2 ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЧИГЛЭЛЭЭР:**


Нийслэлийн хэмжээнд Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн нэгдсэн тоон мэдээ 2021 оны 5 дугаар сарын 25-ны байдлаар /өссөн дүнгээр/ **99156** эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:



Эд хөрөнгийн улсын бүртгэлийн энэ оны эхний хагас жилд иргэдэд үзүүлсэн үйлчилгээ нь 2020 мөн үетэй харьцуулахад 21 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### 2.3 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЧИГЛЭЛЭЭР:

Нийслэлийн дүүргүүд, төвүүдэд Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг шилжүүлсэн өнгөрсөн оны 8 дугаар сараас эхлэн авч эхэлсэн бөгөөд 2021 оны 5 дугаар 25-ны байдлаар нийт 8224 бүртгэл хийгдсэн байна. Үүнд:



**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2021 онд иргэдэд үзүүлсэн үйлчилгээ нь 2020 оны бүртгэлээс 64 дахин бүртгэлээр өссөн үзүүлэлттэй байна.**

Энэ оны эхний хагас жилд өмнөх оноос 64 дахин өссөн байна. Энэ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг 2021 оноос нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв болон дүүрэг дэх улсын бүртгэлийн хэл+тсүүдээс үзүүлдэг болсонтой холбоотой. Энэ нь үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах томоохон ажил болсон юм.

**Дээрх 3 төрлийн улсын бүртгэлийн үйлчилгээний төрлөөр 2021 оны 5 сарын байдлаар Нийслэлийн хэмжээнд нийт 322628 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.**



Тус газрын 2021 онд иргэд, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээ нь 2020 оны мөн үеийнхээс 11 хувиар буурсан байна. 2021 онд бүртгэлийн үйлчилгээний тоо буурсан нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй гадаад зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай холбоотой үндэсний энгийн гадаад паспорт олголтын бүртгэлийн үйлчилгээний эрс багассантай холбоотой.

### 2.4. УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Архивын хэлтэс нь Төрөөс архивын үйл ажиллагааны талаар явуулж буй бодлого чиглэлийг нийслэлийн бүртгэлийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааны явцад бий болсон баримтыг архивт хүлээн авах, нөхөн бүрдүүлэлт хийх, эмхлэн цэгцлэх, нягтлан шалгах, журмын дагуу хадгалж хамгаалах, ашиглуулах, лавлагаа



мэдээлэл, хуулбар олгох, данс , тоо бүртгэл хөтлөх, архивын ажлын хяналт шалгалт хийх, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдийн архивын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Нийслэл дэх улсын бүртгэлийн газрыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулан баталж, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой авах арга хэмжээний тухай А/06 дугаар тушаалыг хэрэгжилтийг ханган ажилласан. Уг тушаалын хүрээнд иргэний баримтын архивын сан хөмрөг, байгууллагын тоног төхөөрөмж нүүлгэн шилжүүлэх ажлын хэсэг, архивын хадгаламжийн нэгжийг тоолох тооллогын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, эд хогшлын тооллогын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тус тус байгуулсан. 2021 оны 3 дугаар сард тус газрын Баянзүрх дүүрэг 1 дүгээр хороо, Денверийн гудамж, Монгол банкны D байранд нүүлгэн шилжүүлсэн. Дээрх хугацаанд иргэний баримтын архивын 2184 хайрцаг архивын баримтыг 29 удаагийн тээвэрлэлтээр нүүлгэсэн байна. Нүүлгэн шилжүүлэх хугацаанд ямар нэг асуудал, алдаа дутагдал гараагүй болно.

❖ **Нөхөн бүрдүүлэлтийн чиглэлээр:** Нийт **48753** баримт иргэний баримтын архивт хүлээн авсан. Үүнээс 9 дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс **41464** баримт, орон нутгийн бүртгэлийн хэлтсээс **7289**, эх нотлох баримт **493** хадгаламжийн нэгж, баримт архивт хүлээн авч, нягтлан шалган, ангилан төрөлжүүлсэн.

❖ Сан хөмрөгт байрлуулах **47857** баримтыг он цаг, нэрийн дараалалд оруулан галиглан цэгцэлсэн.

❖ Галиглаж цэгцэлсэн **32489** баримтыг хадгаламжийн санд байрлуулсан байна.

Иргэний баримтын цахимжуулалтын сангаас олгосон лавлагааг үндэслэн мэдээллийн санд **2** бүртгэлийг нөхөн оруулахаар иргэний улсын бүртгэлийн газарт албан бичгээр хүргүүлсэний үндсэн дээр дээрх иргэдийн бүртгэлийн зөрчлийг арилгуулан ажилласан.

Архивын баримтын ашиглалт: Нийт **62588** лавлагаа, мэдээлэл олгосон.

Иргэний хувийн хэргийн бүрэн бүтэн байдлыг хангах үүднээс нягтлан шалгах шаардлагатай **18361** баримтыг сүлжээнд шалгаж, холбогдох газарт хүргүүлэх, бусад сан хөмрөгт шилжүүлэн байрлуулах ажлуудыг хийсэн.

Бүртгэлийн зөрчлийн арилгахад **45** баримтыг хуулбарлан холбогдох ажилтан, иргэнд олгосон.

### **2.5 Хяналт шалгалтын ажлын хүрээнд:**

Энэ оны эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөт шалгалт-12, гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт-15, өргөдөл санал гомдлын мөрөөр хийсэн шалгалт-797, гүйцэтгэлийн шалгалт 6 нийт 830 бүртгэл хяналтын шалгалт хийж ажилласан.

Тайлангийн хугацаанд: /2021 оны 5 дугаар сарын 25-ны байдлаар/

- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-28091
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-4367
- Хуулийн этгээдийн чиглэлээр-369
- Архивын чиглэлээр-240 нийт **33067** бүртгэлд байнгын хяналт тавьж, 350 зөрчил илрүүлэн, хяналтын улсын байцаагчийн 1267 дүгнэлт гарч, 6966

иргэн, хуулийн этгээдэд нийтдээ 197.516.000 /нэг зуун ерэн долоон сая таван зуун арван зургаа / төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хялбаршуулсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлэсэн даруй Нийслэл болон дүүргийн прокурорт хянуулж, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж байгаа бөгөөд тайлангийн хугацаанд 3 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

УБЕГ-ын даргын 2021 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн “Шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт шалгалт хийх удирдамж”, мөн өдрийн Хяналт, шалгалтын газрын даргын 8/1364 дүгээр албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 2021 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс хойших хугацаанд хийгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийн эх нотлох баримтад хяналт шалгалт хийж, хянасан тухай тэмдэглэгээ хийсэн нотлох баримтыг PDF хэлбэрээр файл

үүсгэн, шалгалтын дүн мэдээний хамт Хяналт, шалгалтын газарт хүргүүлсэн.

2021.01.25-ны өдөр Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын даргын баталсан “Худалдаа үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдийг QR кодоор бүртгэлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байдалд нийслэлийн агентлаг, харьяа байгууллагуудын хяналт тавьж ажиллах хуваарь”-ийн дагуу 01 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах аж ахуй нэгж байгууллагад хяналт тавьж ажиллан холбогдох хяналт шалгалтын мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.

## **ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

### **3.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн зохион байгуулах ажлын хүрээнд:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах үүрэг бүхий Улсын бүртгэлийн ерөнхий газар /цаашид “УБЕГ” гэх/-ын даргын 2021 оны А/11 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт тус газраас орж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө /6 бүлэг бүхий 94 арга хэмжээ бүхий/-г баталсан. 6-р сарын 10-ны байдлаар 75 арга хэмжээ буюу 100 хувийн гүйцэтгэлтэй дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэний тоог хороо бүрээр 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар гарган дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17 дахь хэсэгт заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах журам” болон маягт, загвар /байгууллагын цахим хуудсанд байршуулж, нээлттэй хэлэлцүүлсэн ба Сонгуулийн ерөнхий хороо, холбогдох газар, хэлтсээс санал авсан/, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Сонгуулийн ерөнхий хорооны хамтарсан 2021 оны А213/38 дугаар тушаал/тогтоолоор баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах журам” боловсруулахад саналаа хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэрийг зарласан сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн хүлээн авч, нягтлан шалгаж, тогтоолд заасан сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрийн мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь сонгогчийн бүртгэлд 2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр бүрэн тусгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах журам”-ын 2.5, 2.6-д заасны дагуу тухайн сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийг сонгогчдын нэрийн жагсаалтад үнэн зөв, давхардал, зөрчилгүй тусгасан эсэхийг нягтлан шалгаж, сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, 4 дүгээр сарын 1-ний өдөр [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим хуудсанд байрлуулж, иргэдийг өөрийн болон байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн сонгогчийн мэдээлэлтэй танилцах боломжоор ханган ажилласан.

Цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтыг 24 цаг тутамд шинэчилж байхаар тохиргоог хийж, тогтмол шинэчилж байгаа бөгөөд цахим хуудсанд байрлуулсан

сонгогчдын нэрийн жагсаалттай 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар хандалт хийсэн иргэний тоо 45668 байна. Үүнээс 44475 иргэн мэдээллээ алдаагүй зөв гэж баталгаажуулсан бөгөөд 1193 иргэний мэдээлэл зөрүүтэй гэжээ. Мэдээлэл зөрүүтэй иргэдийн мэдээллийг тухай бүр шийдвэрлэж, 7 хоног тутам мэдээллийг нэгтгэн ажиллаж байна. 2021 оны 5-р сарын 7-ны байдлаар 488 зөрүүтэйг зөрчлийг арилгаж ажилласан.

“Иргэний бичиг баримтын зөрчил арилгах” 2 сарын аян зохион байгуулж, зөрчлийг арилгуулж хяналт тавьж ажиллаж байна. Аяны хугацаанд дүүргүүдийн хороодын улсын бүртгэгч, хорооны Засаг дарга, ажлын хэсгийн ахлагч, хэсгийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэйгээр хорооны хүн амын судалгаанд тулгуурлан иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сантай тулгалт хийж ажилласан ба Нийслэлийн 9 дүүргийн 171 хороодод бүртгэлтэй 1541471 иргэн хамрагдахаас 1376646 иргэд буюу 89 хувь нь хамрагдсан байна. Илэрсэн зөрчлүүдийг арилгуулах чиглэлээр Багануур 100 хувь, Багахангай 100 хувь, Баянгол 95 хувь, Баянзүрх 29 хувь, Налайх 24 хувь, Сонгинохайрхан 15 хувь, Сүхбаатар 69 хувь, Хан-Уул 98 хувь, Чингэлтэй 24 хувийн гүйцэтгэлтэй тус тус ажилласан. Аяны хугацаанд бүртгэлийн нийт 13833 иргэний зөрчлийг илрүүлснээс 7448 иргэний буюу 54 хувийн зөрчлийг арилгуулсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/215 дугаар тушаалын дагуу иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг 4 дүгээр сарын 10-ны өдрөөс зогсоож, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны “Шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт шалгалт хийх удирдамж”-ийн дагуу 1 дүгээр сарын 2-ны өдрөөс иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг зогсоох хүртэлх хугацаанд бүртгэгдсэн иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн 30512 бүртгэлд хяналт тавьж, 597 зөрчлийг илрүүлж, илэрсэн зөрчлийн 86.4 хувийг арилгасан байна. Үүнээс нийслэлд 17785 бүртгэлд хяналт тавьж, 269 зөрчлийг илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасны дагуу нийслэлийн 457 хэсэгт улсын бүртгэлийн 583 итгэмжлэгдсэн ажилтан ажиллуулахаар саналаа хүргүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/239, А/264 дүгээр тушаалаар шийдвэрлүүлсэн /итгэмжлэгдсэн ажилтныг 2500 ба түүнээс дээш сонгогчтой сонгуулийн хэсэгт 1 итгэмжлэгдсэн ажилтан нэмэгдэнэ/. Бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах 906 иргэдийн материалыг Тагнуулын ерөнхий газарт хүргүүлэн 906 иргэний талаарх саналыг авч 583 иргэнтэй гэрээ байгуулан улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнаар томилоод байна.

Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны ажиллах техник, тоног төхөөрөмжид үйлдлийн системийг бэлтгэж, загвар файлыг 4 дүгээр сарын 29-ний өдөр бэлтгэж, 30-ны өдрөөс тоног төхөөрөмжид үйлдлийн системийг хуулах ажлыг эхлүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэгт заасны дагуу Улсын дээд шүүх, Батлан хамгаалахын яам, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар зэрэг төрийн 6 байгууллагатай мэдээлэл солилцох, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/221 дугаар тушаалаар байгуулж, дундын программын эрхийг нээж, мэдээлэл хүлээн авах ажлыг эхлүүлж өөрчлөлтийг мэдээллийн санд тусгасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэг”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх,

танилцуулах журам"-ын 3.3,3.4,3.5-д заасны дагуу өөрчлөлт оруулсан сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө цахим сангаас 2 хувь хэвлэж, 1 хувийг сонгуулийн хэсгийн хороонд, 1 хувийг улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд олгоно гэсний дагуу хуулийн хугацаанд 457 хэсгийн 1010384 сонгогчийн 928063 үндсэн сонгогч, 82321 түр хасав тэмдэглэгээтэй 39772 хуудас бүхий сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэж, сонгуулийн хэсгийн хороодод хүргэх ажлуудыг зохион байгуулж ажиллаа.

Тус газрын дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүд 2021 оны 5 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд батлагдсан хуваарийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан эрх зүйн цахим сургалтыг зохион байгуулж, нийслэлийн хэмжээний нийт 457 хэсгийн хороонд ажиллавал зохих 584 итгэмжлэгдсэн ажилтнаас гэрээ байгуулсан 562 буюу 96 хувь нь хамрагдсан байна.

Уг сургалтаар “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, сонгогч шилжих журам”, “Төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалт, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах”, “Итгэмжлэгдсэн ажилтны чиг үүрэг, гүйцтгэх ажил”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Байгууллагын үйлчилгээний стандарт” сэдвүүдээр хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгч нар холбогдох эрх, зүйн актууд танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1,24.2,24.3 дахь хэсэгт заасан дараах этгээд сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих 5-р сарын 25-ны 23.59 цаг минутаар тасалбар болгож дүүрэг дэх бүртгэлийн хэлтэс ажилласан. Нийслэлийн хэмжээнд 2682 сонгогч шилжин ирж, 2753 сонгогч шилжин явсан мэдээтэй байна.

Урьдчилсан байдлаар сонгогчийн нэрсийн жагсаалтыг 2 хувь үйлдэж хэсгийн хороонд шилжүүлэн өгсөн хэвлэлттэй холбоотой принтерийн хор бичгийн цаас бусад бичиг хэргийн материалыг УБЕГ-ын даргын А/176 тоот тушаалын дагуу бэлтгэж холбогдох дүүрэгт хуваарилж, сонгуулийн техник хэрэгсэл хүлээн авах, буцааж татах хуваарь гаргаж нүүлгэлтийн компанитай гэрээ хийж зардлыг шийдвэрлэж тоног төхөөрөмжийг дүүрэг дэх Тагнуулийн Газар, Цагдаагийн хэлтэсээс хамгаалалт авч сургалт болох байранд татан авсан.

Итгэмжлэгдсэн ажилтануудын техникийн сургалт хийх, сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх ажлын хүрээнд сургалтын хоол, байрны түрээсийн зардлуудыг дүүргүүдэд хуваарилж, мэдээлэлийн санд өөрчлөлт оруулсан лавлагааг хэвлэх, сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэхтэй холбоотой бичиг хэргийн зардлыг хуваарилж бэлтгэл ажлыг хангаад байна..

БНСУ-ын Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл”-ийн хүрээнд техник, тоног төхөөрөмж болон коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх 220000 маск, 2520 гар ариутггагч, 200 /хайрцганд 50 ширхэгтэй/ хамгаалалтын бээлий, нэг удаагийн хамгаалалтын малгай 500 хайрцаг, нүүрний хамгаалалт 500, ариутгалын шүршигч машин, ариутггагч хаалга нийт 223763 ширхэг халдвар ариутгалын хэрэгслийг нийслэлийн 9 дүүрэгт тараан бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.

Тус газрын дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүд 2021 оны 6 дугаар сарын 3-4-ны өдрүүдэд УБЕГ-аас батлагдсан хуваарийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан мэдээллийн технологийн болон эрх зүйн сургалтыг танхимаар зохион байгуулав.

Уг сургалтаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн

бүртгэлийг нягтлах шалгахтай холбоотой анхаарах асуудлууд, сонгогчийн бүртгэлийн программ хангамж, тоног төхөөрөмжийн хэрхэн ашиглах талаар улсын бүртгэлийн байгууллагын ажилтан нарыг нэгдсэн удирдлагаар хангах ажлыг УБЕГ, ИБГ, МТГ, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүд хамтран зохион байгуулж ажиллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтанд өөрчлөлтийг тусгаж хэвлэж сонгуулийн хэсгийн хороодод хүргэх ажлыг амжилттай зохион байгуулсан.

2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг ханган тоног төхөөрөмжүүдийг суурилуулан 2021 оны 6 дугаар сарын 9-ний өдөр сонгуулийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, ямар нэг зөрчил дутагдалгүй ажилласан.

## **ДӨРӨВ.КОВИД ЦАР ТАХЛЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД**

### ***Бүх нийтийн өндөржүүлсэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлсэн ажил***

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар /Гамшгаас хамгаалах бүртгэл мэдээллийн алба/ нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшиг ослын үед орон гэргүй болсон иргэдийг бүртгэх, сураггүй алга болсон иргэдийн мэдээллийг гаргаж удирдлагад танилцуулах, мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулж, гамшиг ослын үед иргэний бүртгэл, судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цуглуулах, хуулийн этгээд, иргэнд шаардлагатай лавлагаа, мэдээлэл гаргаж өгөх гэсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 391 тоот албан бичгийн дагуу хөдөлгөөнт төхөөрөмжөөр мэдээллийн сангийн сүлжээг Нийслэлийн онцгой комисст байршуулан Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үед цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор Нийслэлийн онцгой комиссын ажиллагааны багийн бүрэлдэхүүнд тус газрын Архивын хэлтсийн мэргэжилтэн нар ээлжлэн ажиллаж халдвар тээгчтэй шууд болон дам хавьтсан иргэдийн лавлагаа, мэдээллийг тухай бүр гарган мэдээллээр шуурхай хангаж ажиллаж байна.

Мөн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ажилласан тухай мэдээлэл /бүртгэлийн тоо болон Коронавирусын халдвар авч эерэг гарч батлагдсан тохиолдол, одоо эмчлэгдэж байгаа, тусгаарлалтад байгаа, эдгээд гарсан албан хаагчдын тоон мэдээ/-ийг өдөр бүр нэгтгэн гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Нийслэлийн онцгой комиссын Шуурхай штабт тус тус хүргүүлж ажиллаж байна.

## **ГАМШГААС ХАМГААЛАХ БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН 2021 ОНЫ 2 ДУГААР САРЫН 11-23-НЫ ӨДРҮҮДЭД**

**2021 оны 2 дугаар сарын 8-ны өдрөөс 10-ны өдрүүдэд бэлтгэл ажил хангасан талаар:**

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлж, хязгаарлалтын дэглэм тогтоосон 2021 оны 2 дугаар сарын 8-ны өдрөөс 10-ны өдрүүдэд Нийслэл дэх Улсын бүртгэлийн газраас нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд эргүүлээр ажиллах албан хаагчдын нэрсийг гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдөр хүргүүлэв.

Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу нийт албан хаагчдын 5 хүртэлх хувийг ажиллуулах чиглэлийн дагуу тус газар болон дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэст ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарь батлан ажиллуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/85 дугаар захирамжийн дагуу “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд 2021 оны 2 дугаар сарын 8-ны өдрөөс 10-ны өдрүүдэд 400 албан хаагчдыг PCR

шинжилгээнд хамруулсан.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед ажиллах албан хаагчдад ажлын газрын тодорхойлолт олгож, “Нэг хаалга-Нэг шинжилгээ”-г зохион байгуулахад оролцох албан хаагчдад энгэрийн зүүлт хэвлүүлэн өгч, гадуур ажиллахдаа ажлын тодорхойлолт, үнэмлэхийн хамт биедээ тогтмол авч явахыг үүрэг болгож ажиллалаа.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын даргын 2021 оны А/05 дугаар “Гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн анги байгуулах тухай” тушаал гаргаж, бэлэн байдлыг хангуулсан.

### **2021 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс 22-ны өдрүүдэд удирдан зохион байгуулж ажилласан талаар:**

Нийтийн хэв журам сахиулах эргүүлд 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдөр Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын **238** албан хаагч, 2021 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өдөр бүр 87-105 албан хаагч, нийт 293 албан хаагч 2 ээлжээр эргүүлээр ажиллаж, давхардсан тоогоор 1305 удаа эргүүл жижүүр хийсэн байна.

Мөн хариуцлагатай жижүүрийн хуваарийн дагуу тус газар болон дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэст өдөрт 21 албан хаагч, нийт давхардсан тоогоор 78 албан хаагч ажилласан.

Өдөр бүрийн мэдээ, судалгааг холбогдох хүснэгтийн дагуу гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 9:00, 15:00 цагт тухай бүр хүргүүлж байсан.

Мөн эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын унаа, бүх нийтийн амралтын өдөр болон илүү цагийн судалгааг Улсын бүртгэлийн ерөнхий газарт гарган өгч хоол, унааны мөнгийг шийдвэрлүүлж, тухайн дүүрэгт эргүүлээр ажиллаж байгаа албан хаагчдад нэг удаа халуун аарц, хоол, цайгаар хангаж, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж ажилласан.

Хариуцлагатай жижүүр нь тухайн Нийслэл, дүүргийн Онцгой комиссыг халдвар тээгчтэй шууд болон дам хавьтсан иргэдийн лавлагаа, мэдээллээр шуурхай хангаж, нас барсны бүртгэлийг хийж гүйцэтгэсэн. Энэ хугацаанд **349** бүртгэл хийж, Нийслэл, дүүргийн Онцгой комисс, хууль хяналтын байгууллагыг **1661** лавлагаа, мэдээллээр хангаж ажилласан байна.

Мөн Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын ажиллагааны багийн бүрэлдэхүүнд тус газрын Архивын хэлтсийн мэргэжилтнүүд байрлаж, халдвар тээгчтэй шууд болон дам хавьтсан иргэдийн лавлагаа, мэдээллийг тухай бүр гарган мэдээллээр шуурхай хангаж байна.

Нийслэлийн хэмжээнд нийт арван “ЛАВЛАХ УТАС-“аар иргэн, эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээллээр **231** иргэнийг хангасан.

Тус газар болон дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүд нь өрөө, тасалгаа, үйлчилгээний зааланд ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийлээ.

### **“Нэг хаалга-Нэг шинжилгээ” ажлын хүрээнд:**

Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдөр баталсан “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд нийт **210** албан хаагч дүүргийн Онцгой комиссын баг, ажлын хэсэгт орж хороодод ажилласан.

Энэ хугацаанд манай **278** албан хаагч “Нэг хаалга-Нэг шинжилгээ”-нд хамрагдсан.

Мөн “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд тус шинжилгээнд хамрагдсан нийт **323** албан хаагчдын одоо амьдарч байгаа хаягийн мэдээлэл болон хамт амьдарч буй гэр бүлийн гишүүдийн мэдээллийг UB-ERP системд бүртгэж,

байршууллаа.

## **ГАМШГААС ХАМГААЛАХ БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН 2021 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 10-24-НИЙ ӨДРҮҮДЭД**

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлж, хязгаарлалтын дэглэм тогтоосон хугацаанд Нийслэл дэх Улсын бүртгэлийн газраас нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд эргүүлээр ажиллах албан хаагчдын судалгаа, Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд ажиллах албан хаагчдын судалгаа болон тээврийн хэрэгслийн судалгааг тус тус гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, бүх нийтийн бэлэн байдлын үед ажиллах албан хаагчдад ажлын газрын тодорхойлолт олгож ажиллалаа.

Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу нийт албан хаагчдын 10 хүртэлх хувийг ажиллуулах чиглэлийн дагуу тус газар болон дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэст ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарь баталж, мэдээг нэгтгэн Улсын бүртгэлийн ерөнхий газар болон нийслэлийн онцгой комисст тогтмол цаг хугацаанд хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд **3417** бүртгэл хийж, **4387** лавлагаа олгосон байна.

Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын ажиллагааны багийн бүрэлдэхүүнд тус газрын Архивын хэлтсийн мэргэжилтнүүд байрлаж, халдвар тээгчтэй шууд болон дам хавьтсан иргэдийн лавлагаа, мэдээллийг тухай бүр гарган мэдээллээр шуурхай хангаж байна.

Нийслэлийн хэмжээнд нийт арван “ЛАВЛАХ УТАС-“аар иргэн, эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээллээр **1470** иргэнийг хангаж ажиллалаа.

Энэ хугацаанд **123** албан хаагчдыг PCR шинжилгээнд хамруулсан.

Тус газар болон дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүд нь өрөө, тасалгаа, үйлчилгээний зааланд 2-3 удаа ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийлээ.

Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын дарга болон дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн дарга нар Дүүргийн онцгой комиссын гишүүний хувьд дүүргийн онцгой комиссын Шуурхай штабт 2 удаа 24 цагийн үүрэг гүйцэтгэж ажилласан. Мөн дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн дарга нар товчоо, постуудаар явж ажилласан.

Албан хаагчдын Ковид-19-аас сэргийлэх вакцинд хамрагдсан талаарх тоон мэдээлэл, Коронавирусын халдвар авч эерэг гарч батлагдсан тохиолдол, одоо эмчлэгдэж байгаа, тусгаарлалтад байгаа, эдгээд гарсан албан хаагчдын тоон мэдээллийг тус тус нэгтгэн гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН САЛБАРТ КОВИДЫН ҮЕД ТУЛГАРЧ БҮЙ ЭРСДЭЛ:** Ковид-19 цар тахлын үед Нийслэлийн Улсын Бүртгэлийн газар, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдэд дараах эрсдэл тохиолдож байна.

Үүнд:

1. Нийслэл дэх улсын бүртгэлийн газар, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүд өөрийн өмчлөлийн ажлын байргүйгээс улсын бүртгэл, улсын бүртгэгч нэмэгдэх, тусгаарлах өрөө шинээр бий болгон халдвар хамгааллын дэглэмийн дагуу зай барих боломжгүй;
2. Ажилчдын өрөө тасалгаа хүрэлцээ муу тул нэг өрөөнд олуулаа сууж байгаа нь ковид-19 цар тахлаас шалтгаалан үйл ажиллагаа тасалдах, хэсэгчилсэн буюу нийтийг хамарч ажил үйлчилгээний хэвийн байдал алдагдах;
3. Ковид-19 цар тахлаас шалтгаалан албан хаагчид халдварт өвчин тусах; Иргэдийн маскыг тайлж зураг авах, хурууны хээ авахад халдвар тархах;

4. Бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн ачаалал их байгаа зэрэг нь хүний бөөгнөрөл үүсгэж, халдвар тархах эрсдэлийг бий болгож байна.
5. Дүүргүүд дээр өдөрт 3-5 хороо халдваргүйжүүлэлт хийх, сэжигтэй тохиолдол илрэх тэр болгонд бүртгэлийн үйл ажиллагааг зогсоож байна. Тухайлбал:

Баянзүрх дүүргийн Тамгын газрын албан хаагчдаас Ковид-19 халдварт өвчний батлагдсан тохиолдол гарсны улмаас хэлтсийн 30 албан хаагчийг 4 дүгээр сарын 07-ны өдөр PCR шинжилгээнд дахин хамруулсан ба уг шинжилгээгээр 1 албан хаагчаас халдварт өвчний батлагдсан тохиолдол илэрсэн тул ажлын байрыг ариутгах арга хэмжээ авсан ба иргэдэд үйлчлэх үйл ажиллагааг түр зогсоосон. 4 дүгээр сарын 19-ний өдрөөс Ерөнхий боловсролын 55 дугаар сургууль дээр иргэдийг хүлээн авч эхэлсэн боловч давтан шинжилгээгээр дахин 2 албан хаагчаас халдварт өвчний батлагдсан тохиолдол дахин илэрсэн тул үйл ажиллагааг зогсоосон. Өнөөдрийн байдлаар Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын байранд гаднаас хүн оруулахгүй байгаагаас бүртгэлийн үйлчилгээг Ерөнхий боловсролын 55 дугаар сургууль дээр үзүүлж байна.

Баянгол дэх улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчаас КОВИД-19 халдварт өвчний батлагдсан тохиолдол илэрсэн тул 4 дүгээр сарын 26-ны өдөр бүртгэлийн үйл ажиллагааг зогсоож, ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн.

Сонгинохайрхан дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтарч нийт албан хаагчдыг PCR-ын шинжилгээнд 2 удаа хамруулж, халдварын шинж тэмдэг илэрсэн, ойрын хавьталд орсон албан хаагчдыг тусгаарлах арга хэмжээг авч ажилласан.

Чингэлтэй дүүргийн Онцгой комиссоос ЗДТГазрын “Нэг цонхны үйлчилгээ”-ний танхимаар иргэд хүлээн авахгүй байх чиглэл өгсний дагуу 4 дүгээр сарын 18-ны өдрөөс 24-нийг дуустал хугацаанд 09.00-18.00 цагийн хугацаанд хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх хуваарь баталж ажиллуулж байсан.

Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн Оргил ТҮНТ-ийн албан хаагчаас КОВИД-19 илэрснээс шалтгаалан 14 хоног нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагаа доголдож, улсын бүртгэлийн хэлтсийн байранд үйл ажиллагааг төвлөрүүлж явуулсан. Мөн 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын байранд халдвар илэрч тус байранд үйл ажиллагаа явуулдаг хэлтэс, албадын үйл ажиллагааг 2021 оны 4 дүгээр сарын 12 хүртэл бүрэн зогсоож, 4 дүгээр сарын 12-оос зөвхөн улсын бүртгэлийн хэлтсийн 1 дүгээр давхар дахь үйлчилгээний үйл ажиллагааг зөвшөөрсөн.

Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын 2 албан хаагч гэр бүлийн хүнээс халдварлан эерэг гарсан тул нийт албан хаагчдыг 2 удаагийн нэгдсэн шинжилгээнд хамруулж ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийлгэв.

Тус газрын албан хаагчдаас 2021.06.08-ны өдрийн байдлаар Коронавирусын халдвар авч эерэг гарч батлагдсан тохиолдол-43, одоо эмчлэгдэж байгаа-8, эдгээд гарсан-35, тусгаарлалтад-5 албан хаагч байна.

## **Дүгнэлт**

Тус газрын ажилтан, албан хаагчид нь гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн энэ хугацаанд Улс, нийслэл, дүүргийн онцгой комисс, мэргэжлийн байгууллагуудын шийдвэр, зөвлөмж, аюулгүй байдал, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлэн, нийслэл, дүүргийн Онцгой комисс, хууль хяналтын болон холбогдох байгууллагуудыг мэдээллээр шуурхай хангаж ажиллалаа.

## **ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛСАН БУСАД АЖИЛ**



## 5.1 Бусад ажил

5.1.1 Жендерийн үндэсний хорооноос “Монгол цэргийн өдөр буюу 03 дугаар сарын 18-ны өдрийг тохиолдуулан “Би жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг” аяныг өрнүүлсэн. Уг ажлын хүрээнд тус байгууллагаас дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. “Би жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг байна” аяныг зарлан тус газрын <https://niislel.burtgel.gov.mn/post/57446> веб сайт болон дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдийн пэйж хуудсуудаар дамжуулан аяны талаарх мэдээлэл болон фрем, логог байрлуулан сурталчилан ажилласан.

2. Уг аяны хүрээнд нийт албан хаагчдыг “Би жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг байна” гэсэн фремиийг фэйсбүүк хуудсандаа тавихыг уриалан цахим сүлжээ ашигладаг албан хаагчид нь уг фремиийг ашигласан.



5.1.2 2021 оны 05 дугаар сарын 20-нд дүүргийн Улаан загалмайн хорооноос “Дотоодын шилжилт хөдөлгөөний эмзэг байдлыг хязгаарлах нь” төслийн хүрээнд 12 дугаар хороонд шилжин суурьшигчдад зориулсан мэдээллийн өдөрлөгийг зохион байгуулахад оролцон шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэхэд шаардлагатай бичиг баримтын зөвлөгөөг өгч ажиллалаа.



Газар, хэлтсийн албан хаагчид Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон дүүргүүдийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Хоггүй дүүрэг болоё”, “Мод тарья” хаврын их цэвэрлэгээ, тохижилтын арга хэмжээнүүдэд бүгд хамрагдсан байна.



Багануур дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс албан хаагчдыг ая тухтай ажиллах нөхцөлийг бий болгох зорилгоор өөрсдийн хөрөнгөөр 5 дугаар хорооны улсын бүртгэгчийн албан өрөөг засварлан ажиллаа.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан тус газрын нийт ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийн дунд “МИНИЙ ААВ, ЭЭЖИЙН АЖИЛ-МИНИЙ БАХАРХАЛ” сэдэвт гар зургийн уралдааныг 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 28-ныг хүртэл зохион байгуулж ажилласан. Уг тэмцээнийг тус газрын нийт албан хаагчдын хүүхэд, багачуудын авъяас чадварыг нээн хөгжүүлэх, эцэг, эхийн эрхэлдэг ажлын талаар тодорхой ойлголт, мэдлэг олгох, хүүхдийн өөрийн үзэл бодлоо чөлөөтэй, бүтээлч байдлаар илэрхийлэхийг дэмжих, байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор зохион байгуулсан бөгөөд уралдаанд ирүүлсэн зургуудаар үзэсгэлэн гаргаж, оролцсон хүүхдүүдийг шагнаж урамшуулав.







### Сайн үйлсийн хүрээнд:

Нийслэлийн Засаг даргаас Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, дүүргийн харъяа хэлтэс албад, хороод “Дэм дэмэндээ” аяныг зохион байгуулж, айл өрхүүдэд хүнсний тусламж үзүүлэх ажлыг яаралтай зохион байгуулах чиглэл өгсний дагуу дараах арга хэмжээг авч ажиллалаа.

Тус газраас хамтран ажилладаг байгууллагын дэмжлэгээр албан хаагчийн ар гэрийн нөхцөл байдлыг харгалзан 2021 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр 30 албан хаагчид хүнсний тусламж үзүүлэн ажилласан.



Мөн дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтсүүдэд аяны хүрээнд ажил зохион байгуулах үүрэг чиглэл хүргүүлэн ажиллаж дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

1. Багануур дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс албан хаагчдын нэг өдрийн цалин 200,000 төгрөгийг дүүргийн онцгой комисст хандивласан. Дүүргийн зорилтот бүлгийн 28 иргэнд 1 удаагийн хүнсний тусламж, халдвар хамгааллаас сэргийлэх хэрэгслүүдийг тараасан. Мөн 13 албан хаагчдад халдвараас урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих зорилгоор 4 удаагийн нийт 428700 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
2. Баянгол дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс 23 албан хаагчийг витаминжуулалтын багцаар ханган ажилласан байна.
3. Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс 10 албан хаагчид хүнсний тусламж, дүүргийн онцгой комисстой хамтран 5 өрхөд хүнсний багцын тусламж үзүүлсэн.
4. Сонгинохайрхан дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс “Дэм дэмэндээ” аяны хүрээнд тус хэлтсийн 43 хорооны 4 бүсийн улсын бүртгэгч нар 1 дүгээр сарын 6,7-ны өдрүүдэд амьжиргааны түвшин доогуур, бага орлоготой 4 өрхөд хувцас, хүнсний тусламж үзүүлсэн. Мөн хэлтэс дээр ажиллаж байгаа албан хаагчдад иргэн, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг болон Драгон, Баянхошуу нэгдсэн төвүүдийн албан хаагчид ээлжээр өдрийн хоолоор ханган ажиллаж байна.
5. Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс 12 албан хаагчид хүнсний тусламж, 48 албан хаагчид 50,000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн худалдан авах ваучер олгосон.

6. Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс дүүргийн 20 албан хаагч, 48 айл өрхөд хүнсний тусламжийн багц хүргүүлэн ажилласан.
7. Чингэлтэй дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харьяа “Хүүхэд хамгаалах байр”-нд байрлаж буй хүүхдүүдэд болон хамтран ажилладаг 8 дугаар хорооны нийт 40 хүүхдэд 600.000 төгрөгний хүнсний дэмжлэг үзүүлж бэлэг гардууллаа. Мөн 40 албан хаагчид 3.000.000 төгрөгний үнэ бүхий дархлаа дэмжих бүтээгдэхүүнээр тус тус ханган ажилласан байна.



Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын хэмжээнд “Дэм дэмэндээ” аяны хүрээнд тайлангийн хугацаанд амьжиргааны түвшин доогуур, бага орлоготой 125 өрхөд хүнсний багц, 166 албан хаагчид хүнсний болон амин дэмийн багцыг тус тус хүргүүлэн ажилласан байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд, COVID19 цар тахал дэгдсэнтэй холбогдуулан дүүргийн Цагдаагийн постонд ээлжинд гарч буй Онцгой, Цагдаа, Хүн эмнэлгийн албан хаагчдад халуун хоол, цайгаар үйлчиллээ.



### **ЗУРГАА. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР:**

1. Хууль хяналтын болон төрийн бусад байгууллагатай хуулийн хүрээнд ажлаа идэвхтэй уялдуулан хамтарч ажиллах;
2. Иргэд, хуулийн этгээдэд үзүүлж буй бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах;
3. Анхан шатны нэгжээс үзүүлж буй бүртгэлийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор иргэний шинэчилсэн бүртгэл, иргэний үнэмлэх дахин авах бүртгэлийг хороодод шилжүүлэх;
4. Иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хорооноос үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийг шинэчлэх;

### **ДОЛОО. САНАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ**

1. Нийслэл дэх улсын бүртгэлийн байгууллага улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үзүүлдэг. Нийслэл дэх улсын бүртгэлийн газар нь түрээсийн байранд, Дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүд харьяа дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд байрлаж үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд хүн ам, барилга байгууламж жил бүр өсөн нэмэгдэхийн хирээр ажлын байр,

архивын сан хөмрөгийн багтаамж хүрэлцэхгүй байдал үүсч байна. Архивын сан хөмрөгт нийслэлийн 1450000 гаруй иргэдийн хувийн хэрэг материал хадгалагдаж байгаа бөгөөд архивын сан хөмрөг багтаамжгүй болсон байна. Нийслэлийн хэмжээнд бүртгэлийн архив 10 нэгжид байршиж байгаа бөгөөд зориулалтын бус хонгилын давхар, автомашины гражид байгаа нь архивын баримт хадгалах орчны стандарт шаардлагыг хангаж чадахгүй, улсын бүртгэлийн эх нотлох баримт бүхий архив үрэгдэх, устгах өндөр эрсдэлтэй байна.

Иймд тус газар, хэлтсүүдэд ажлын байрны асуудлыг шийдвэрлэх, нягтруулсан шүүгээгээр хангах.

2. Иргэд, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй, ил тод хүргэхэд зайлшгүй хийгдэх шинэчлэл нь төрийн үйлчилгээг цахимжуулах, онлайн хэлбэрт шилжүүлэх явдал юм. Иймд онлайн болоогүй байгаа үйлчилгээнүүдийг үе шаттайгаар онлайн болгох

ТАНИЛЦСАН: ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.АНХНЫБАЯР

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
МЭРГЭЖИЛТЭН:

Б.ЦЭДЭН

